



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 4/318

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21 дэх заалт, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн 3.2.1.1, 3.2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. “Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр, “Жирэмсэн эмэгтэйн үзлэг, шинжилгээний товлал”-ыг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэхийг Эмнэлгийн тусламжийн газар (Я.Буянжаргал), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Энхтөр), Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн салбар зөвлөл (ерөнхий мэргэжилтэн Б.Цэдмаа)-д тус тус даалгасугай.

3. Жирэмсэн, төрөх болон төрсний дараах үед үзүүлэх тусламж, үйлчилгээний журмыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээр судлуулах, нэн шаардлагатай оношлуур, урвалж, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвтөөбагтаан ажиллахыг эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 338 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2020 оны. 06
сарын .04-ны өдрийн А/Б/18 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ЖИРЭМСЭН, ТӨРӨХ, ТӨРСНИЙ ДАРААХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь жирэмсэн, төрөх, төрсний дараах үед эх, ураг, нярайн эрүүл мэндэд тулгарч буй эрсдлийг эрт илрүүлэх, тандах, хүндрэлээс сэргийлэх, эмчлэх, эсэн мэнд амаржуулах, нотолгоонд суурилсан цогц тусламжийг хугацаа алдалгүй үзүүлэхэд чиглэнэ.

Уг журмыг жирэмсэн, төрөх, төрсний дараах үед тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хэрэгжүүлнэ.

Хоёр. Тусламж, үйлчилгээний үндсэн зарчим

2.1 Жирэмсэн эмэгтэй бүрт эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламжийг үзүүлнэ.

2.2 Нотолгоонд тулгуурласан тусламж үзүүлнэ.

2.3 Жирэмсэн эмэгтэй, түүний гэр бүл, хамт олны оролцоог дэмжсэн, үр дүнтэй, идэвхтэй харилцаа тогтооно

2.4 Жирэмсэн эмэгтэйн эрх ашиг, сэтгэл санаа, сэтгэл зүй, соёл, зан заншлыг хүндэтгэн, нууцыг хадгална.

2.5 Жирэмсэн эмэгтэйд эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай үед хүндрэл учруулахгүй, оршин суугаа байршилд ойрхон, харъяалал харгалзахгүйгээр тусламжийг үзүүлэхээр зохицуулна.

2.6 Жирэмсэн, төрөх, төрсний дараа үед эх, ураг, нярайн эрүүл мэндийн талаар нотолгоонд суурилсан мэдээлэл, зөвлөгөө өгч сонголт хийж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлнэ.

2.7 Жирэмснийг эрт илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

2.8 Тусламжийг багаар (эх барих, эмэгтэйчүүд, нярайн эмч, өрх, сумын эмч, эх баригч, сувилагч, бусад шаардлагатай мэргэжлийн эмч) үзүүлнэ.

Гурав. Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

3.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

3.1.1 Эх барих, эмэгтэйчүүд, ураг, нярайн тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

3.1.2 Эх барих, эмэгтэйчүүд, нярайн тусламж, үйлчилгээний чиглэлээр стандарт, зааврын төслийг боловсруулна.

3.1.3. Жирэмсэн, төрөх, төрсний дараах болон нярайн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж бэлтгэнэ.

3.1.4. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг дараах оношийн дагуу хянаж, төрүүлнэ.

3.1.4.1. Зүрхний төрөлхийн болон олдмол гажигтай, зүрх, судасны эмгэгийн үйл ажиллагааны алдагдалтай жирэмсэн эмэгтэй;

3.1.4.2. Зуршмал дутуу тээлтийн үеийн хяналт, жирэмсний тээлтийн хугацаа 32 долоо хоног ба түүнээс доош хугацаанд төрүүлэх бол;

3.1.4.3. Резус сөрөг бүлгийн цустай жирэмсэн (цус мэдрэгшсэн тохиолдолд);

3.1.4.4. Ихэр жирэмсэн үед ургийн эмгэгтэй;

3.1.4.5. Олон урагтай 3 ба түүнээс дээш ихэр жирэмсэн;

3.1.4.6. Үр шилжүүлэн суулгасны дараах жирэмсэн ямар нэг хүндрэлтэй бол;

3.1.4.7. Нярайд хүүхдийн мэс заслын мэргэжлийн тусламж үзүүлэх шаардлагатай;

3.1.4.8. Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийгдсэн;

3.1.5. Тодорхой байрлалтай хорт хавдар нь тогтоогдсон, хүндэрсэн, эх барих болон хавдрын эмчийн онцгой хяналт шаардлагатай;

3.1.6. Шаардлагатай тохиолдолд цахимаар зөвлөгөө өгөх, орон нутагт очиж тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв.

3.2.1. Жирэмсэн болон төрсний дараах үеийн хавсарсан эмгэгтэй эмэгтэйг лавлагаа төвийн үндсэн чиглэлийн дагуу хүлээн авч, тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.2.2. Жирэмсэн эмэгтэй, төрсөн эхийн дуудлагад шуурхай үйлчилнэ.

3.2.3. Лавлагаа төвд эмчлүүлж байгаа жирэмсэн, төрсний дараах үедээ ноцтой хүндэрсэн эмэгтэйд эмч нарын хамтарсан зөвлөгөөнийг шуурхай хийж, оношилгоо, эмчилгээг шийдвэрлэнэ.

3.2.4. Халдварт өвчин судлалын үндэсний төв нь аливаа халдварт өвчинтэй жирэмсэн эмэгтэйд эх барихын тусламж үзүүлэх “Төрөх тасаг”-ийг ажиллуулна.

3.3. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар

3.3.1. Орон нутгийн хэмжээнд жирэмсэн, төрөх, төрсний дараах эх, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар ханган ажиллана.

3.3.2. Орон нутгийг эх барих, эмэгтэйчүүдийн болон нярайн эмч, эх баригч, нярайн сувилагчаар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлнэ.

3.3.3. Орон нутгийн эх барих, эмэгтэйчүүдийн болон нярайн эмч, эх баригч, бага эмч, нярайн сувилагч, сум, өрх, багийн эмч нарыг эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тусламжийн чиглэлээр ажлын байрны сургалтанд тасралтгүй хамруулна.

3.3.4. Жирэмсэн, төрөх, төрсний дараах, нярай үед шаардлагатай оношлуур, урвалж, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр тасралтгүй хангана.

3.3.5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд /БНҮЭМ/, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна.

3.3.6. Орон нутгийн хэмжээнд жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн болон нярайн тусламж, үйлчилгээний байдалд хяналт, үнэлгээ хийнэ.

3.3.7. Жирэмсэн эмэгтэй бүрийг эрт хяналтанд авч, “Нэрийн хяналт”-ын тогтолцоог хэрэгжүүлэх.

3.4. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг (Бүсийн оношилгоо эмчилгээний төв), амаржих газар, эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн эмнэлэг

3.4.1. Стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан тухайн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартад заасны дагуу хүний нөөц, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

3.4.2. Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт ажиллаж буй мэргэжлийн удирдлага, арга зүйгээр ханган, эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарт сум, хороог хариуцуулан уялдаа холбоог хангаж, эргэх холбоотой ажиллана.

3.4.3. Жирэмсэн, төрөх, төрсний дараах тусламж, үйлчилгээнд эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч, төрөх тасгийн эрхлэгч, поликлиник, амбулаторийн эрхлэгч, чанарын менежер дотоодын хяналт тавина.

3.4.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс илгээсэн жирэмсэн эмэгтэйд эх барих, эмэгтэйчүүдийн эмч үзлэг хийж, шинжилгээнд дүгнэлт өгч, дараагийн хяналт руу шилжүүлнэ.

3.4.5. Төрөлжсөн мэргэшлийн эмч нь эх барих, эмэгтэйчүүдийн болон өрх, сум, тосгоны эмчийн илгээсэн жирэмсэн эмэгтэйг үзэж, өвчнийг илрүүлэн, эмчилнэ.

3.4.6. Өндөр эрсдэлтэй жирэмснийг тээлгэх эсэх асуудлыг эх барих, эмэгтэйчүүдийн болон төрөлжсөн мэргэшлийн эмч нар хамтран үзэж, хугацаа алдахгүй шийдэж, харъяаллын дагуу амаржих газар, төрөх тасагт эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

3.4.7. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг эх барих, эмэгтэйчүүдийн эмч, хавсарсан эмгэгтэй тохиолдолд төрөлжсөн мэргэшлийн эмчтэй хамтран хянаана.

3.4.8. Шаардлагатай тохиолдолд жирэмсэн эмэгтэй, төрсөн эхийг хугацаа харгалзахгүй үзэж, хэвтүүлэн эмчилж, дараагийн шатлалын тусламж, үйлчилгээнд шилжүүлнэ.

3.4.9. Төрөлт болон ноцтой хүндрэлийн талаарх мэдээллийг харъяаллын дүүрэг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд өгнө.

3.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв

3.5.1. “Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа”, “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа”-ны стандартад заасны дагуу хүний нөөц, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

3.5.2. Үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл судалгааг гаргаж, жил бүр шилжилт хөдөлгөөнийг хийж, гэр бүл төлөвлөлтийн болон бусад тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ашиглана.

3.5.3. Үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар түр алдалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.5.4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг жирэмслэхэд бэлтгэж зөвлөгөө өгөх, шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

3.5.5. Жирэмслэлт хэвийн үргэлжилж байгаа, эх барихын ужиг өгүүлэмжгүй жирэмсэн эмэгтэйчүүдийг хянах ба жирэмсний 20, 32 долоо хоногтойд эх барих, эмэгтэйчүүдийн эмчид үзүүлж, зөвлөгөө авна.

3.5.6. Алслагдсан нутагт амьдарч байгаа амьжиргааны түвшин доогуур жирэмсэн эмэгтэйчүүдийг төрөхөөс 07-14 хоногийн өмнө сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эхийн амрах байранд амруулна.

3.5.7. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйд хяналт тавьж, эх барих, эмэгтэйчүүдийн эмчид үзүүлэхэд дэмжлэг үзүүлж, төрөхөөс 07-14 хоногийн өмнө нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг/ амаржих газарт илгээнэ.

3.5.8. Эх, нярайг товллын дагуу гэрээр эргэж, зөвлөгөө өгч, үзлэг хийнэ.

3.5.9. Жирэмсэн эмэгтэй бүрийг эрт хяналтад хамруулахад нийгмийн ажилтан, олон нийт, эрүүл мэндийн идэвхтний дэмжлэгийн авч, хамтран ажиллана.

Хүснэгт 1. Эрүүл мэндийн байгууллагуудын нөхөн үржихүйн насны эмэгтэйд үзүүлэх тусламж, үйлчилгээ

Тусламж үйлчилгээ	Багийн эмч	Өрх, сум, тосгоны ЭМТ	Нэгдсэн эмнэлэг /БОЭТ/	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв
Жирэмслэхээс өмнөх тусламж үйлчилгээ				
Харьяаллын нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл, судалгааг гаргана.	+	+	-	-
Өсвөр насны охидод урьдчилан сэргийлэх үзлэг хийж, эрүүлжүүлэн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.	-	+	+	+
Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд /БНҮЭМ/, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгоно.	+	+	+	+
Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх арга хэмжээ авна.	+	+	+	-
Жирэмсэлтэд бэлтгэх зөвлөгөө өгч, тусламж үзүүлнэ.	+	+	+	+
Гэр бүл төлөвлөлтийн тусламж	+	+	+	+

үйлчилгээ үзүүлнэ.				
Жирэмсэн үеийн тусламж үйлчилгээ				
Жирэмсэнг эрт илрүүлнэ.	+	+		
Жирэмсэн эмэгтэйд эрүүл мэндийн зөвлөгөө өгнө.	+	+	+	+
Эхээс хүүхдэд ХДХВ, гепатитийн В вирус, тэмбүүгийн халдвар дамжихыг таслан зогсооно.	+	+	+	+
БЗДХ-аас сэргийлэх тухай зөвлөгөө өгнө.	+	+	+	+
Жирэмсэн эмэгтэйг хянаана.	-	+	+	+
Жирэмсний өндөр эрсдлийг үнэлж, илрүүлнэ.	-	+	+	+
Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлнэ.	-	+	+	-
Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг хянаана.	-	-	+	+
Шаардлагатай тохиолдолд хэвтүүлэн эмчилнэ.	-	+	+	+
Шаардлагатай тохиолдолд пренатал илрүүлэг, оношилгоо хийнэ	-	-	+	+
Төрсний дараах тусламж, үйлчилгээ				
Төрсөн эхийн мэдээллийг төрсний дараах 24 цагийн дотор солилцоно.	-	+	+	+
Эх, нярайг гэрээр товлолын дагуу эргэж, үзлэг хийж, зөвлөгөө өгнө.	+	+	-	-
Шаардлагатай тохиолдолд хэвтүүлэн эмчилнэ.	-	+	+	+
Гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө өгч, үйлчлүүлэгчид сонголт хийхэд дэмжлэг үзүүлж, тусламж үйлчилгээг үзүүлнэ.	+	+	+	+

Хүснэгт 2. Жирэмсний өмнөх, жирэмсэн, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэл

	Тусламж үйлчилгээ
1.Жирэмслэхээс өмнө	<ul style="list-style-type: none"> ○ Үйлчлэх хүрээний нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл, судалгаа хийнэ. ○ Үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар түр алдалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. ○ Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн бүлгээр ангилан эмчлэн, эрүүлжүүлж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. ○ Жирэмсэлтэд бэлтгэх зөвлөгөө өгч, тусламж үзүүлнэ. ○ БНҮЭМ, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгоно.
2.Жирэмсэн эхийн асуумж, өгүүлэл	<p>Жирэмсний эхний үзлэг <u>Асуумж авах</u></p> <ul style="list-style-type: none"> ○ Одоогийн жирэмсэнтэй холбоотой ○ Өмнөх жирэмсэн, төрөлтийн талаарх мэдээлэл ○ Эрүүл мэндийн дурьдатгал ○ Нийгмийн байдал ○ Ажлын нөхцөл ○ Хүчирхийлэл <p><u>Өндөр эрсдлийг илрүүлэх жирэмсний хугацаа</u></p> <ul style="list-style-type: none"> ○ Жирэмсэн эмэгтэйг анх хяналтад авахад ○ 20 долоо хоногтой ○ 28 долоо хоногтой ○ 36 долоо хоногтой
3.Жирэмсэн үеийн үзлэг	<p>Жирэмсэн эмэгтэйн хяналтын эхний үзлэгийг заавал их эмч хийнэ <u>Жирэмсэн эмэгтэйд зайлшгүй хийгдэх үзлэг</u></p> <ul style="list-style-type: none"> ○ Ерөнхий биеийн үзлэг хийх, ○ Артерийн даралтыг 2 гарт үзэх, ○ Судасны лугшилтыг тоолох, ○ Биеийн жин, өндөрийг хэмжих, ○ Хөхний үзлэг хийх, ○ Умайн ёроолын өндөр хэмжих, ○ Хэвлийн тойрог хэмжих, ○ Эх барихын гадуур үзлэг хийх, ○ Ургийн зүрхний цохилт чагнах, ○ Үтрээний үзлэг хийх, ○ Толины үзлэг хийх.
4.Жирэмсэн	

<p>эмэгтэйд хийгдэх сорил, шинжилгээ</p>	<p><u>Өрх, сүм, тосгоны ЭМТ-д:</u></p> <ul style="list-style-type: none"> ○ Жирэмсний сорил ○ Цусны бүлэг ○ Резус бүлэг тодорхойлох ○ Тэмбүү илрүүлэх хурдавчилсан арга ○ ХДХВ-ын эсрэг бие илрүүлэх хурдавчилсан арга ○ Элэгний В, С вирус илрүүлэх ○ Шээсэнд уураг илрүүлэх ○ Шээсэнд саахар үзэх, ○ Цусанд гемоглобины хэмжээ тодорхойлох <p><u>Шинжилгээ:</u></p> <ul style="list-style-type: none"> ○ Цусны ерөнхий шинжилгээ ○ Шээсний ерөнхий шинжилгээ ○ Тэмбүү илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээ (хурдавчилсан аргаар эерэг гарсан үед онош баталгаажуулах) ○ ХДХВ-ийн эсрэг бие илрүүлэх шинжилгээ(хурдавчилсан аргаар эерэг гарсан үед онош баталгаажуулах) ○ Үтрээ, умайн хүзүүний наацын (нойтон түрхэц) шинжилгээ ○ Шээсэнд нян илрүүлэх ○ Хэт авиан шинжилгээ ○ Ургийн зүрхний бичлэг (заалтаар) ○ Рентген шинжилгээ (заалтаар) ○ Биохимийн шинжилгээ (заалтаар) ○ Цусны дэлгэрэнгүй шинжилгээ (заалтаар) ○ Умайн хүзүүний эсийн шинжилгээ (заалтаар) ○ “ТоRCH” халдварыг илрүүлэх (заалтаар) ○ Стрептококкийн халдварыг үзэх (заалтаар) ○ Пренатал илрүүлэг (заалтаар) ○ Пренатал оношилгоо (заалтаар)
<p>5.Жирэмсэн үеийн зөвлөгөө, мэдээлэл</p>	<p><u>Зөвлөгөөний сэдэв:</u></p> <ul style="list-style-type: none"> ○ Жирэмсний хяналтын ач холбогдол ○ Жирэмсэн эмэгтэй өөрийгөө хэрхэн хянах тухай ○ Амны хөндийн эрүүл мэнд ○ Жирэмсэн үеийн хоол ○ Хорт зуршил, архи тамхины хор, дам тамхидалтаас сэргийлэх ○ Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх ○ Жирэмсний эмгэг байдал /аюултай шинжүүд ○ Төмрийн бэлдмэл, фолийн хүчил, бичил элемент, амин дэм хэрэглэхийн ач холбогдол ○ Зулбалт, дутуу төрөлтөөс сэргийлэх ○ Цус багадалтын тухай ○ Эрхтэн тогтолцооны эмгэгийн талаар ○ Төрөлтийн тухай /төрлөг эхлэх шинж/ ○ Жирэмсний хожуу хордлогын тухай ○ Хөх арчлах тухай

	<ul style="list-style-type: none"> ○ Төрөлтөд бэлтгэх ○ Хүчирхийллээс ангид байх ○ Эхээс хүүхдэд дамжих халдвар /ХДХВ/ДОХ, Тэмбүү, гепатитийн В вирус/, ○ Сэтгэл зүйн бэлтгэл ○ Илүү тээлтийн тухай ○ Төрөх үеийн өвдөлтийг бууруулах аргууд ○ Төрсний дараа үе ○ Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж /асаргаа, сувилгаа, дулаан алдалтаас сэргийлэх, ○ Дутуу нярайн “Имж- эх” асаргаа ○ Гэр бүл төлөвлөлт ○ Халдварт өвчин илэрсэн бол холбогдох зөвлөгөөг өгөх ○ Жирэмсэлт, төрөлттэй холбоотой хууль эрхзүйн ойлголт <p><u>Зайлшгүй өгөх мэдээлэл:</u></p> <ul style="list-style-type: none"> ○ Эмийн аюулгүй хэрэглээ ○ Жирэмсэн үеийн хувцаслалт ○ Жирэмсний дасгал хөдөлгөөн ○ Хэт авиан шинжилгээг хийх хугацаа ○ Ургийн хөдөлгөөнийг хянах тухай ○ Даруулга хэрэглэхийн ач холбогдол ○ Жирэмсэн үед аялах /агаарын тээврээр зорчих, жолоо барих/ ○ Төрлөгийн үеийн туслагч ○ Кесар мэс заслын талаарх ойлголт ○ Хүүхдээ эрт амлуулах, эхийн сүүгээр хооллох ○ Гэр бүлийн оролцоог дэмжих ○ Пренатал илрүүлэг, оношилгооны тухай ○ Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн тухай ○ Төрсний дараах үзлэг, гэрийн эргэлтийн талаар
<p>6. Жирэмсний хяналтын явцад хийгдэх бусад тусламж, үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> ○ Жирэмсний хугацаа болон төрөх хугацааг тодорхойлно. ○ Үзлэгийн явцад илрүүлсэн асуудлуудыг эхэд таниулна. ○ Тухайн жирэмсний эрсдлийг үнэлнэ. ○ Хяналтын дараагийн хугацааг товлон. ○ Эхийг эрүүлжүүлэх төлөвлөгөө гаргана. ○ Жирэмсэн эмэгтэй бүрт төмөр, фолийн хүчлын бэлдмэлийг сэргийлэх тунгаар хэрэглэхийг зөвлөнө. ○ Заалтаар кальцийн бэлдмэл уулгана. ○ Шаардлагатай нэмэлт шинжилгээ, үзлэгийг хийнэ. ○ Амаржих газрыг товлон. ○ Жирэмсэн эмэгтэйг анх хяналтанд авахдаа “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”, “Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч” маягтыг олгоно. ○ “Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч”-ийг зааврын дагуу хөтөлнө. ○ Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч”-ийг эмэгтэйд өгч, үзлэгт

	<p>ирэх бүрт авч ирэхийг зөвлөнө.</p> <ul style="list-style-type: none"> ○ Үзлэг хийсэн эмч бүр “Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч”-тэй үзлэг хийх бүрт танилцана. ○ Хяналтын хугацаанд жирэмсэн эмэгтэйг /нөхөр, гэр бүлийнхний хамт/эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд 4-өөс доошгүй удаа хамруулна. ○ Жирэмсэн үеийн дасгалд хамруулна. ○ Жирэмсэн эмэгтэйд төрөхийн өмнөх болон төрсний дараах чөлөөний хуудсыг олгоно. /Тухайн үеийн мөрдөж байгаа хуулийг үндэслэнэ/ ○ Эмэгтэйд “Солилцох хуудас”-ыг жирэмсний 20 долоо хоногтойд хөтөлж олгоно. ○ Төрсний дараа солилцох хуудасны Б хэсгийг амаржих газар хөтөлж олгоно
<p>7.Төрсний дараах үеийн тусламж</p>	<p>Эхэд үзүүлэх тусламж</p> <ul style="list-style-type: none"> ● Төрөлтийн талаар эх болон ар гэрийнхэнд мэдээлэл өгнө. ● Ерөнхий биеийн үзлэг хийнэ. ● Хүндрэлийг эрт илрүүлэх ба хүндрэлээс урьдчилан сэргийлнэ.(халдвар, цус алдалт, цус багадалт) <p>Зөвлөгөө</p> <ul style="list-style-type: none"> ● Хооллолтын тухай ● Төрсний дараа илрэх аюултай шинжүүд (цус алдах, халуурах, толгой өвдөх, дотор муухайрах, хэвлийгээр өвдөх) ● Хөхний арчилгаа, эхийн сүүгээр хооллолт ● Нярайн асаргаа сувилгаа, нярайн аюултай шинж ● Аюулгүй бэлгийн харьцааны тухай ● Цус багадалтаас урьдчилан сэргийлэх, (төмөр,фолийн хүчлийн нэмэлт) ● Гэр бүл төлөвлөлт, төрсний дараа жирэмслэхээс хамгаалах тухай <p>Нярайн эрт үед үзүүлэх тусламж, үйлчилгээ</p> <ul style="list-style-type: none"> ● Нярайг хуурайшуулна. ● Арьс арьсаар шүргэлцүүлнэ (Анхны тэврэлт). ● Нярайд малгай өмсгөнө. ● Хүйг зөв хугацаанд зөв хөндөнө. ● Ангир уургийг 1 цагийн дотор амлуулна. ● Нүдний сувилгаа хийнэ. ● Аминдэм “К” нярайн булчинд тарина. ● Нярайн биеийн байдлыг үнэлэх, хянах, хүндрэлийг илрүүлж, эмчилнэ. (амьсгалын хямрал, халдвар, дутуу болон бага жинтэй нярай, гэмтэл, гаж хөгжил гэх мэт) ● Нярайг 24 цагийн дотор усанд оруулахгүй. ● Төрсний дараах ерөөнд орох хүртэл эх, нярайг хамтад нь байлгаж, хянана.

	<ul style="list-style-type: none"> • Амьдралын эхний 24 цагийн дотор В гепатит, БЦЖ, Саагийн эсрэг дархлаажуулалтыг хийнэ. (дархлаажуулалт хийхийн өмнө эхэд заавал хэлж, тайлбарлана). <p>Эх нярайд хамтад нь үзүүлэх тусламж</p> <ul style="list-style-type: none"> • Төрсний дараах үзлэг, гэрийн эргэлт • Төрсний дараа эх, нярайг үзнэ: <ul style="list-style-type: none"> - Эхний 24 цагийн дотор - Төрсний дараах 3 дахь хоног - Төрсний дараах 7 дахь хоногт заавал үзэж зохих тусламж үйлчилгээг үзүүлнэ. - Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй үзнэ. • Эх, нярайг төрсний дараах 5-6 дахь долоо хоногт давтан үзнэ.
--	--

Дөрөв. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг илрүүлж, хянах

4.1. Жирэмсний өндөр эрсдэлт байдлыг “А,Б,В,Г” гэсэн дөрвөн бүлэгт ангилж илрүүлнэ.

4.2. Тухайн жирэмсэнг хянаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь жирэмсэн эмэгтэйг анх хяналтанд авах болон жирэмсний 20,28,36 долоо хоногтойд асуумж, үзлэг шинжилгээг үндэслэн өндөр эрсдлийг илрүүлж тогтооно.

4.3. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг өрх, сум, тосгоны эмч эх барих, эмэгтэйчүүдийн эмчтэй давхар хянаана.

4.4. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэй бүрт тохирсон хяналтын товлол, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.5. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэн эмэгтэйг хэвтүүлэн эмчлэх шаардлагатай бол жирэмсний 28 долоо хоногийн дотор аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд эмчилнэ.

Хүснэгт 3. Өндөр эрсдэлтэй жирэмснийг илрүүлэх асуумж

Эрсдлийн бүлэг		Нөлөөлөх хүчин зүйл
А	Нийгэм биологийн хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> ○ 18-аас доош насны тулгар төрөгч, ○ 30-аас дээш насны тулгар төрөгч, ○ 35-аас дээш насны жирэмсэн, ○ 5 ба түүнээс олон төрсөн, ○ Нэн ядуу жирэмсэн эмэгтэй, ○ Хоол тэжээлийн дутагдалтай, ○ Байнга тамхи татдаг, архи уудаг, мансууруулах бодис хэрэглэдэг /доогуур зур/ ○ Хүчирхийлэлд байдаг.
Б	Эх барихын ужиг дурьдатгал	<ul style="list-style-type: none"> ○ Өмнөх жирэмсэн, төрөлт, төрсний дараах үед цус алдаж байсан ○ Өмнөх жирэмсэн, төрөлтийг мэс засал, мэс

		<p>ажилбараар төгссөн</p> <ul style="list-style-type: none"> ○ Өмнөх жирэмсний үед манас таталтын урьдал, манас таталт, үжил халдвараар хүндэрсэн ○ Зуршсан зулбалт, үр хөндөлт, дутуу төрөлт, умайн гаднах жирэмсэн, цулцант хураа, өсөлтгүй жирэмсэн ○ Ураг, нярай нь эндэж байсан ○ Удамшлын болон төрөлхийн хөгжлийн гажигтай хүүхэд төрүүлж байсан ○ Эмэгтэйчүүдийн мэс ажилбар хийгдэж байсан, умайн хавдар авахуулсан, хярзанд мэс ажилбар хийгдсэн бусад ○ Үргүйдэлтэй байсан
В	Эрхтэн тогтолцооны эмгэг	<ul style="list-style-type: none"> ○ Зүрх судасны эмгэг: Артерийн даралт ихсэх өвчин хэрлэг, төрөлхийн гажиг, бусад ○ Амьсгалын замын эмгэг: Багтраа, хатгалгаа, бусад ○ Хоол боловсруулах замын эмгэг: Ходоодны шархлаа, элэгний архаг үрэвсэл, элэгний хатуурал, бусад ○ Бөөр, шээсний замын эмгэг: Өрөөсөн бөөртэй, гидронефроз, нефрит, бөөрний хурц ба архаг дутагдал, халдвар ○ Дотоод шүүрлийн булчирхайн эмгэг: Бамбайн эмгэг, чихрийн шижин, тураал, хоол тэжээлийн дутагдал, аминдэм эрдэс бодисын дутагдал, бусад ○ Цусны өвчин: Цус багадалтын 2,3,4-р зэрэг, цусны бусад өвчин ○ Хөхний болон эмэгтэйчүүдийн өвчин: Хөхний эмгэгүүд, дайвруудын үрэвсэл, умай умайн хүзүүний үрэвсэл, эндомиетроз, бусад ○ Халдварт өвчин: Сүрьеэ; ХДХВ/ДОХ, тэмбүү, заг хүйтэн, трихомониаз, хламид, элэгний үрэвсэл, бэлэг эрхтний хомхой, бусад ○ Нүдний өвчин: холын харалган-2,3-р зэрэг, нүдний даралт ихдэлт, бусад ○ Сэтгэцийн өвчин, ○ Мэдрэлийн өвчин, ○ Холбогч эдийн өвчин, ○ Аутоиммуны өвчин, ○ Удамшлын өвчин, ○ Хорт хавдар, ○ Эрхтэн шилжүүлэх мэс засал хийгдсэн, ○ Резус сөрөг бүлгийн цустай, ○ Таргалалт, ○ Бусад
Г	Одоогийн жирэмсний явцад эмгэг	<ul style="list-style-type: none"> ○ Жирэмсний эрт үеийн хордлого (хүнд хэлбэр) ○ Жирэмсний үеийн цус алдалт ○ Манас таталтын урьдал

	байдал илэрсэн	<ul style="list-style-type: none">○ Ургийн буруу байрлал○ Ургийн удамшлын эмгэг, төрөлхийн хөгжлийн гаж хөгжил○ Олон урагт жирэмсэн,○ Ихэс түрүүлэлт, хүйн эмгэг,○ Үр шилжүүлэн суулгасан,○ Ураг орчмын шингэний ихдэлт,○ Ураг орчмын шингэний багадалт,○ Ургийн өсөлтийн саатал,○ Ургийн бүтэлт.
--	-------------------	---

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06...
 дугаар сарын 04-ны өдрийн 04... дугаар
 тушаалын хоёрдугаар хавсралт.



ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЛОЛ

Хүснэгт 1. Жирэмсэн эмэгтэйн үзлэгийн товллол

Үзлэгийн дугаар	Жирэмсний хугацаа	Үзлэгийн зорилго	Анхаарах зүйл
1	12 долоо хоногийн дотор	<ul style="list-style-type: none"> Асуумжийг бүрэн авна Үзлэгийг бүрэн хийнэ Жирэмсний хугацааг тодорхойлно. Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. Жирэмсэнг тээлгэх эсэх асуудлыг шийднэ. 	<p>Эхний үзлэгийг их эмч заавал хийнэ.</p> <p>Өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг төрөлжсөн мэргэшлийн эмчид үзүүлж зөвлөгөө авна, шаардлагатай тохиолдолд эх барих эмэгтэйчүүдийн эмчийн хяналтад шилжүүлнэ.</p>
2	20 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. Ургийн бүтэц болон ихэс, хүйн байдлыг шинжилнэ. 	<p>Солилцох хуудсыг олгоно.</p> <p>Жирэмсний явц хэвийн үед ч эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна.</p>
3	24 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянана. 	-
4	28 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянана. Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. 	-
5	32 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Жирэмсний амралт олгоно. Сүрьеэ илрүүлэх асуумж авна. 	<p>Жирэмсний явц хэвийн үед ч эх барих эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна.</p>
6	36 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянана. Жирэмсний өндөр эрсдлийг илрүүлнэ. 	<p>Төрүүлэх газрыг товллоно.</p>

7	38 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Жирэмсний явц, ургийн өсөлт хөгжилтийг хянана. 	Төрөлтийн төлөвлөгөөг боловсруулна
8	39-40 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Төрөлтөнд бэлтгэгдсэн байдлыг үнэлнэ Ургийн жинг тодорхойлно. 	

Тайлбар. Жирэмсний 41 долоо хоногт төрөөгүй бол жирэмсэн эмэгтэйг эмнэлэгт хэвтүүлж, төрүүлэх арга хэмжээ авна.

Хүснэгт 2. Жирэмсэн үед хийгдэх шинжилгээ

Жирэмсний хугацаа	Хийгдэх шинжилгээ
Анхны үзлэг	<ul style="list-style-type: none"> Жирэмсний сорил Цусны бүлэг Резус бүлэг ХДХВ-ын эсрэг бие илрүүлэх хурдавчилсан арга Элэгний В, С вирус илрүүлэх Тэмбүү илрүүлэх хурдавчилсан арга Шээсний ерөнхий шинжилгээ Үтрээ, умайн хүзүүний наацын (нойтон түрхэц) шинжилгээ Хэт авиан шинжилгээ Цусны ерөнхий шинжилгээ
11-13 ⁺⁶ долоо хоног	Эхний 3 сарын пренатал илрүүлэг (заалтаар)
12-16 долоо хоног	Шээсэнд нян илрүүлэх
16-20 долоо хоног	2 дахь гурван сарын илрүүлэг (эхний илрүүлэг хийгдээгүй эсвэл заалтаар)
18-22 долоо хоног	Ургийн бүтцийн хэт авиан шинжилгээ
28 долоо хоног	Тэмбүүгийн сорил давтах
32 долоо хоног	<ul style="list-style-type: none"> Шээсний ерөнхий шинжилгээ Үтрээ, умайн хүзүүний наацын (нойтон түрхэц) шинжилгээ Хэт авиан шинжилгээ Цусны ерөнхий шинжилгээ

Жирэмсэн эмэгтэйд сүрьеэ өвчин илрүүлэх, хянах

1. Жирэмсэн эмэгтэйг анх хяналтанд ирэх болон 32 долоо хоногийн үзлэгийн үед дараах асуумж авна:

- Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байсан уу?
- Гэр бүлд нь сүрьеэгээр өвчилсөн хүн байгаа юу?
- 14 хоногоос дээш хугацаагаар ханиалгаж байна уу?
- Шалтгаангүй халуурч байна уу?
- Биеийн жин буурч, турж байна уу?
- Цэр, цустай цэр гарч байна уу?
- Шөнөдөө хөлрөх зовиур илэрч байна уу?

2. Бүх асуултад **ҮГҮЙ** гэж хариулбал **СЭЖИГГҮЙ** гэж дүгнэнэ.

3. Нэг асуултанд **“ТИЙМ”** гэж хариулбал **СҮРЬЕЭТЭЙ БАЙЖ БОЛЗОШГҮЙ** гэж дүгнэн, мэргэжлийн эмчид илгээнэ.

4. Мэргэжлийн эмч нь жирэмсэн эмэгтэйг үзэж, оношилгоо, эмчилгээг шийдвэрлэнэ.

5. Жирэмсэн эмэгтэйд сүрьеэ өвчин оношлогдвол эх барих, эмэгтэйчүүдийн болон сүрьеэгийн эмч хамтран хянана.

6. Эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөгөөнөөр жирэмсний хугацаанаас хамаарч, тээх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Төгсөв.